

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН**  
/2022.09.26 - 2022.09.30/

2022.09.26

Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Үйл ажиллагааны гүйцэтгэл
<b>Барилга хот байгуулалтын хэлтэс</b>		
1	Барилгын үйлдвэрлэлийн чиглэлээр	✓ Шинээр зөвшөөрөл авсан Тайван хайрхан ХХК, Сисмон ХХК-уудыг ирүүлж холбогдох баримт бичгийг хүлээн авч мэдээллийн санд бүртгэсэн.
2	Инженерийн дэд бүтэц	<ul style="list-style-type: none"> <li>• Дархан сумын 13-р багт үйлдвэрийн раойнд баригдсан ТК80-ТК94 худгийн хоорондох дулааны шугамын шинэчлэлийн ажилд улсын комисс ажилласан.</li> <li>• Дархан сумын 14-р баг Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд баригдсан Хүүхдийн төмөр замын гүйцэтгэлийн зураг төслийг хянаж мэдээллийн санд оруулсан.</li> <li>• Дархан-Уул аймгийн Хонгор суманд баригдаж байгаа цэвэрлэх байгууламжийн засварын ажлын барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон.</li> </ul>
<b>Газрын удирдлагын хэлтэс</b>		
1	Суурь судалгаа газрын мониторинг	<ol style="list-style-type: none"> <li>1. Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Прокурорын газарт шалгагдаж байгаа иргэн, ААНБ -ын нийт 8 албан бичгийн лавлагааг газрын кадастрын системээс аймгийн хэмжээнд шүүж хариуг хүргүүлсэн.</li> <li>2. 2023 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ байршил, зориулалтыг Дархан сумын иргэдийн төлөөлөгчдийн зөвлөлийн хурлаар эхний байдлаар хэлэлцүүлсэн.</li> </ol>
2	Газрын кадастрын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> <li>✓ Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж, хуваалт / тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагуудаар хэмжилт хийлгэсэн 4 иргэний материалыг хүлээн авч мэдээллийн санд оруулж кадастрын зураг гаргасан.</li> <li>✓ Өмчлөлийн газраа худалдах, өвлүүлэх, бэлэглэх гэрээгээр шилжүүлж байгаа нийт 16 иргэний цахим хүсэлтийг мэдээллийн санд өөрчлөлт хийж, кадастрын зургийг гаргаж өгсөн.</li> <li>✓ 2022 оны 09 сарын 28-ны өдөр Театр дээр зохион байгуулагдсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгт оролцож 40 гаруй иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаа.</li> </ul>
<b>Захиргаа аж ахуйн чиглэл</b>		
1	Хүний нөөц, хууль эрх зүй	<p>Үүрэг даалгавар:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Аймгийн ЗДТГ-ын 2022/09/20-ны өдрийн №2-10/1279 албан тоотын дагуу АТГ-ын ХШДШХ-ийн чиг үүрэгт хамаарах асуудлаар ГХБХБГ-ын ЭБАТ ЗХАХМэргэжилтэн Б.Золбаясах 2022/09/23-нд Аймгийн ХЭЗХэлтэсд хүснэгтийн дагуу тайлан мэдээг хүргүүлсэн.</li> <li>✓ ТАЗөвлөлөөс аймгийн төрийн байгууллагуудад “Хүний нөөцийн аудит хийх удирдамж”-д заасан Чадахуйн зарчмын хэрэгжилтийг хангуулах зорилт, арга хэмжээний 2019-2022 онуудын хүний нөөц, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөрүүдийн биелэлтийг боловсруулах бэлтгэх ажлыг хангуулах ажлыг хэсэг, төлөвлөгөөг гаргаж газрын даргаар батлуулсан.</li> </ul>
2	Мэдээллийн технологи, нярав	<p><b>Мэдээлэл:</b> 70376471 нээлттэй утсаар 0 иргэн /Нүүж өөр өрөөнд орсон тул утасны үзүүр орж ирээгүй тул/, байгууллагын Facebook хуудсанд ирсэн 10 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв.</p> <p><b>Мэдээлэл технологийн чиглэлээр:</b> Байгууллагын цахим хуудасны Ил тод байдал цэсний Санхүүгийн мэдээ хэсэгт 2022 оны 7, 8-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг оруулав.</p> <p>2022 оны бэлчээрийн газрын фотомониторингийн тайланд хэрэглэх Хонгор, Орхон, Шарын гол сумдын зургуудыг нэгтгэн эхийг бэлтгэж Мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэнд өгөв.</p> <p>Архивын бүртгэлийн *.xlsx өргөтөлтэй гэмтсэн файлыг сэргээхийн тулд Microsoft Excel файлыг сэргээдэг 10</p>

	<p>төрлийн програмыг хайж олон татаж суулган, сэргээхийг оролдож, сэргээж өгөв.</p> <p><b>Нярав:</b></p> <p>Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 2 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 22 ширхэгийг хүлээж авч бүртгэв.</p> <p>Шаардах хуудсаар 2 төрлийн 61 ширхэг бараа материал олгов.</p>
--	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Тайлан боловсруулсан:  
Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн  
Хянасан:  
Газрын удирдлагын хэлтсийн дарга

Б.Золбаясах  
Г.Нямдорж